

БЭЭЖИНГИЙН ОЛИМП – 2008

Бээжин хотын орлогч дарга, Олимпийн наадмыг зохион байгуулах хорооны орлогч дарга Лю Жинминий мэдээлснээр, Бээжингийн Олимпийн наадмыг зохион явуулах цэнгэлдэх хүрээлэн болон холбогдох бусад арга хэмжээний барилга байгууламжийн бүтээн байгуулалтанд нийт 3,4 тэрбум ам.доллар зарцуулах урьдчилсан тооцоо гарчээ.

Бээжингийн Олимпийн наадмыг зохион байгуулах хорооны хурлаас нийтдээ тэмцээний 37 цэнгэлдэх хүрээлэн (түүнээс 32 нь Бээжин дэх спортын талбай багтаж байна) болон бэлтгэл хийх 59 цэнгэлдэх хүрээлэн, үүнээс гадна Олимпийн тосгон хэвлэл мэдээллийн төв гэх мэт холбогдох арга хэмжээнд зориулсан барилга байгууламж барих хэрэгтэй аж.

Лю Жинминь, Олимпийн тэмцээнийг явуулах спортын 37 цогцолборын 19-ийг шинээр байгуулах шаардлагатай байгаа үүний тулд 14.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх, Олимпийн тосгон, хэвлэл, мэдээллийн төв, радио телевизийн төв байгуулахын зэрэгцээ барилга барих, спортын цогцолборуудыг засварлахад ойролцоогоор 19.4 тэрбум ам.доллар зарцуулах урьдчилсан тооцоо гарсныг мэдэгдэв.

Тэрбээр хэлэхдээ, Засгийн газрын чиг бодлогыг үндэслэн төв цэнгэлдэх хүрээлэн болон холбогдох бусад арга хэмжээний бүтээн байгуулалтын хөрөнгө зардлыг зах зээлийн үйл ажиллагааны арга хэлбэрийн дагуу зээлээр гүйцэтгэх ба “спортын зарим цогцолборыг тэмцээн дууссаны дараа бүрэн ашиглахыг чухалчилж байна. Жишээ нь: Олимпийн цэцэрлэгт хүрээлэн доторхи 19000 хүний багтаамжтай спортын цогцолборыг Хятадын циркийн үзүүлбэрийн төв болгож, улмаар Олимпийн тосгон дахь усан санг усаар наадах зугаа цэнгэлийн хүрээлэн болгоно” гэв.

Бээжин хотын дарга, Олимпийн наадмыг зохион байгуулах хорооны дарга Лю Жинминь мөн Бээжингийн Олимпийн спортын цогцолборуудын байршлын ерөнхий төлөвлөгөөг танилцуулав. Тэр хэлэхдээ, Бээжингийн Олимпийн спортын цогцолборыг “нэг чухал төв + 3 дүүрэг” гээд үүнд: Олимпийн цэцэрлэгт хүрээлэн нь Бээжингийн Олимпийн “төвийн гол дүүрэг” дотор нь 13 талбайтай. “Баруун хэсгийн хэвлэлийн дүүрэг” 9 талбайтай үүний дотор шинээр соёл, спортын 5 төвийг байгуулна, тэмцээн дууссаны дараа хотын дүүргийн баруун урд хэсэгт сургууль соёл, спортын үйл ажиллагааны талбай болно; “Их сургуулийн дүүрэгт” нийслэлийн спортын ордон зэрэг 4 ордонг хуваарилаад байна, тэмцээний дараа их сургууль болон хэвлэл мэдээллийн дүүрэг соёл, спортын үйл ажиллагааны талбар болно. “Хойд хэсэгт аялал жуулчлалын дүүрэг”-ийг Бээжингийн морин тойруулга зэрэг спортын 2 ордонг хуваарилаад байна, тэмцээний дараа аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх захын дүүрэг болно. Үүнээс гадна, бусад дүүрэгт ажилчдын биеийн тамир спортын г.м 4 ордон барьж өргөжүүлнэ.

Лю Жинминь, Бээжингийн Олимпийн наадмын зарим ордон болон холбогдох бусад арга хэмжээний барилга байгууламжийг хувьцаа эзэмшүүлэх арга хэлбэрээр ашиглаж, нээлттэй нийгэмд зориулан нийгмийн хяналтыг хүлээн зөвшөөрч, Олимпийн тэмцээний талбай, ордон болон бусад холбогдох арга хэмжээний барилга байгууламжийг үр дүнтэй, цэвэр ариун үйлст зориулан үйл ажиллагаа явуулахаа илэрхийлэв.

www.beijing2008.com 2005.08.08

ОЛИМПИЙН НААДМЫН ЗАМ ТЭЭВЭР, ТАСАЛБАРЫН АСУУДАЛ

2008 онд Бээжин хотод болох Олимпийн наадамд зориулсан зам тээврийн асуудал дараах зүйлүүдээс бүрдэнэ. Үүнд: 2008 оны Олимпийн наадамд зориулан нисэх онгоцны буудлын зорчих талбайг 480000-600000 хүн дамжин өнгөрөхөөр төлөвлөн өргөтгөж барих, метро дамжуулах чадавхийг нэмэгдүүлэх, барьж байгаа хурдны замыг дуусгах г.м.

Хотын орчин үеийн зам харилцааны асуудлыг шинжлэх ухаан, техникийн шаардлагын дагуу сайжруулна. Энэ жил Олимпийн наадамд зориулж шинээр гэрлэн дохио 128-ыг байрлуулснаар Бээжин хотын замын нэвтрүүлэх чадвар 15%-иар дээшлэх ажээ. Мөн хэв журмыг чангатган хуулийн дагуу хүмүүс замын хөдөлгөөнд соёлтой оролцох, дугуйтай хүмүүс болон жирийн явган зорчигчдыг осол эндлээс хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээ авах ажээ.

ОЛИМПИЙН НААДМЫН ТАСАЛБАРЫН ҮНИЙН ТУХАЙД

2008 оны Олимпийн наадмын тасалбарыг хэдийнээс борлуулж эхлэх хугацааг одоогоор шийдээгүй бөгөөд үнийг тогтоохдоо жирийн ард иргэдийн худалдан авах чадварыг харгалзах ажээ. Олимпийн наадамд дэлхийн бөмбөрцгийн бараг бүх улс орны тамирчид оролцдог биеийн тамир спортын томоохон баяр

наадам болохоор Хятадын ард иргэд олноороо үзэж сонирхох хандлагатай байгааг Бээжин хотын Олимпийн наадмыг зохион байгуулах хороо зүй ёсоор ухамсарлаж, тасалбарын үнийг аль болохоор хүртээмжтэй тогтоохыг хичээж байгаа. Зарим нэг онцгой чухал тэмцээний үзвэрийн тасалбар харьцангуй өндөр үнэтэй байх шаардлагатай боловч нийт үнийн асуудлыг ирэх жилээс шийдвэрлэх ажээ.

Цэнгэлдэх хүрээлэнгийн индэр, сэтгүүлч, сурвалжлагчид байрлах талбайг тохижуулж, аюулгүй байдал, хамгаалалтыг найдвартай, иж бүрэн хангах юм байна. Тэмцээний хуваарийг ирэх жилээс боловсруулан гаргаж борлуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хятадын өнцөг булан бүрээс ирэх үзэгчдийн тоо хэмжээг Олимпийн хороо тусгайлан авч үзэж, аль болох хүнд суртал, төвөггүйгээр шийдвэрлэхийг хичээн эрмэлзэж байна. Харин гадаадын зочид, төлөөлөгчид, сонирхогчдын асуудлыг тухайн улс бүрд зохих журмаар шийдвэрлэх юм байна. Одоогоор оролцох хүмүүсийн тоог 9 саяар тооцож байгаа нь зөвхөн урьдчилсан тоо бөгөөд цаашид өөрчлөгдөх болно гэжээ.

www.sportsonline.com 2005.11.11

Бэлтгэсэн: Б.Хулан. ШУА-ийн
ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ажилтан